



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/220

Улаанбаатар хот

Томилолтоор ажиллуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6 дахь заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны "Журам батлах тухай" 98 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам"-ын 4.5 дахь заалт, Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56 дугаар тушаалаар батлагдсан "Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээ тогтоох тухай" журмын 6.3 дахь заалт, төвийн Ерөнхий захирлын 2017 оны А/183 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөө орон нутагт мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт авах, төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад 2012-2016 онд улсын төсвийн санхүүжилтээр хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүдийн төрийн сангийн гэрээний хэрэгжилтэд хяналт хийх ажлын удирдамж"-ийг нэгдүгээр, "Орон нутагт ажиллах албан хаагчдын нэрс, хуваарь"-ийг хоёрдугаар, Албан томилолтод шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Гуравдугаар хавсралтад дурдагдсан зардлыг төсвийн дотоод албан томилолтын зардлаас тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Мэргэжилтэн Д.Дондогмаа, С.Лхагвадорж нарыг томилолтоор ажиллах хугацаанд албан ажил үүргийг нь зохицуулж ажиллахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.
4. Ажлыг холбогдох журам, удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж тайланг ажлын гурав хоногт багтаан танилцуулахыг мэргэжилтэн Д.Дондогмаа, С.Лхагвадорж нарт даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНТУЯА

2017 оны 12 сарын 07 өдрийн

Ерөнхий захирлын
дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

**ХӨДӨӨ ОРОН НУТАГТ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТ АВАХ, ТӨГСӨЛТИЙН ДАРААХ ҮНДСЭН БОЛОН
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТАД 2012-2016 ОНД УЛСЫН ТӨСВИЙН
САНХҮҮЖИЛТЭЭР ХАМРАГДСАН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ТӨРИЙН
САНГИЙН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ХИЙХ, АЖЛЫН УДИРДАМЖ**

2017-12-07

Үндэслэл:

Монгол Улсын Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Журам батлах тухай” 98 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”-ын 4.5-д заасны дагуу хөдөө орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнүүдээс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт авах, Монгол улсын эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56 дугаар тушаалаар батлагдсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээ тогтох тухай” журмын 6.3 дахь хэрэгжилтэд хяналт хийх

Зорилго:


Хөдөө орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнүүдээс зөвшөөрлийн шалгалт авах, төрийн сангийн гэрээний хэрэгжилтэд хяналт хийх үйл ажиллагааг зохион байгуулах

Гүйцэтгэх ажил:

1. Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Журам батлах тухай” 98 дугаар тушаалын 5.4. дэх заалтын дагуу Увс, Ховд аймгийн эмнэлгийн мэргэжилтнүүдээс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт авах
2. Төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад 2012-2016 онд улсын төсвийн санхүүжилтээр Увс, Ховд аймгаас хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний төрийн сангийн гэрээний хэрэгжилтэд хяналт хийх
3. Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Журам батлах тухай” 98 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”, Эрүүл мэнд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан 2013 оны 491/А/472 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”, Монгол улсын эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56 дугаар тушаалаар батлагдсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээ тогтоох тухай” журмыг танилцуулах, сурталчлах

Байршил: Увс, Ховд аймгийн төвд


2017 оны 12 сарын 07 өдрийн Агаар дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



ОРОН НУТАГТ АЖИЛЛАХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС, ХУВААРЬ

№	Албан тушаал	нэр	Хаана	хугацаа
1	Эрүүл мэндийн хөгжлийн албаны мэргэжилтэн	Д.Дондогмаа	Ховд	2017.12.08-10
2	Эрүүл мэндийн хөгжлийн албаны мэргэжилтэн	С.Лхагвадорж	Увс	2017.12.09-10

Ерөнхий захирлын
2017 оны...сарын...өдрийн...дугаар
тушаалын гуравдугаар хэвсрэлт



АЛБАН ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Явах чиглэл:

УЛААНБААТАР- ХОВД-УЛААНБААТАР

Д/д	Албан тушаал	Тооцох зам хоног	Хүний тоо	Албан томилолтын хугацаа	Нийт зам хоногийн зардал
1	Зам хоног /хоол/	14,000	1	3	42,000
2	Зочид буудал	35,000	1	2	70,000
3	Онгоц: УБ-Ховд-УБ	206,300	1		412,600
	ДҮН				524,600

Явах чиглэл:

УЛААНБААТАР- УВС-УЛААНБААТАР

Д/д	Албан тушаал	Тооцох зам хоног	Хүний тоо	Албан томилолтын хугацаа	Нийт зам хоногийн зардал
1	Зам хоног /хоол/	14,000	1	3	42,000
2	Зочид буудал	35,000	1	2	70,000
	ДҮН				112,000

НИЙТ ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ

636,600

Хянасан: Ахлах нягтлан бодогч

Боловсруулсан: Нягтлан бодогч

Д.Гантуяа

С.Лхагвасүрэн